



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 41,864,921.00 (дөчин нэгэн сая найман зуун жаран дөрвөн мянга есөн зуун хорин нэгэн) төгрөгийн балансын үнэ, 12,785,100.35 (арван хоёр сая долоон зуун наян таван мянга нэг зуун төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хил хамгаалах ерөнхий газар (Хилийн 0243 дугаар анги), Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанд балансаас балансад тус тус шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Л.Баттөр болон тогтоолд заасан байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ



0000228

Төрийн эмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн
100 дугаар тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН
НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР, ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН
АЛБАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк (dell optiplex 3060, i5)	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Компьютер (dell optiplex 3060, i5)	2018/12/07	2,602,100.00	10	26,021,000.00	5,637,883.31	20,383,116.69	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
	Дүн				26,021,000.00	5,637,883.31	20,383,116.69	
1	Сейф (электрон кодтой)	2012/04/12	396,000.00	1	396,000.00	306,900.00	89,100.00	
2	Буйдан кресло (214-2012)	2012/06/26	1,308,000.00	1	1,308,000.00	991,900.00	316,100.00	
3	Ширээ (өндөр, дугуйтай, 313)	2015/11/01	438,900.00	1	438,900.00	182,875.00	256,025.00	
4	Сандап (мэргэжилтэн)	2015/01/02	229,000.00	5	1,145,000.00	572,500.20	572,499.80	
5	Сандап	2013/09/09	178,200.00	1	178,200.00	112,860.00	65,340.00	
6	Сейф (AICO 500*440*620)	2014/06/24	700,055.00	2	1,400,110.00	770,060.28	630,049.72	
7	Телевизор (sharp14X3БГ)	2010/02/06	152,991.00	1	152,991.00	151,716.56	1,274.44	
8	Хөргөгч	2011/12/08	418,500.00	1	418,500.00	338,287.50	80,212.50	
9	Бичгийн ширээ (терийн сан)	2013/09/09	679,800.00	3	2,039,400.00	1,291,620.00	747,780.00	
10	Шүүгээ (дугуйтай, түмбочка)	2014/10/30	239,580.00	1	239,580.00	125,779.50	113,800.50	
	Дүн				7,716,681.00	4,844,499.04	2,872,181.96	
1	Компьютер HP IDS G3 i7	2018/07/27	2,031,810.00	1	2,031,810.00	575,679.50	1,456,130.50	
2	Компьютер HP IDS G3 i7	2018/07/27	2,031,810.00	1	2,031,810.00	575,679.50	1,456,130.50	
3	Компьютер HP IDS G3 i7	2018/07/27	2,031,810.00	1	2,031,810.00	575,679.50	1,456,130.50	
4	Компьютер HP IDS G3 i7	2018/07/27	2,031,810.00	1	2,031,810.00	575,679.50	1,456,130.50	
	Дүн				8,127,240.00	2,302,718.00	5,824,522.00	
	Нийт дүн				41,864,921.00 (дөчин нэгэн сая найман зуун жаран дөрвөн мянга есөн зуун хорин нэгэн төгрөг)	12,785,100.35 (арван хоёр сая долоон зуун наян таван мянга нэг зуун төгрөг гучин таван мөнгө)	29,079,820.65 (хорин есөн сая далан есөн мянга найман зуун хорин төгрөг жаран таван мөнгө)	Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба